



83

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 40

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дэх хэсгийн 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг. Г.Тувааны нэрэмжит Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн 40,152,816 /дөчин сая нэг зуун тавин хоёр мянга найман зуун арван зургаа/ төгрөгийн балансын үнэтэй 34,506,857 /Гучин дөрвөн сая таван зуун зургаан мянга найман зуун тавин долоо/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хавсралтад дурьдсан барилга байгууламжийг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

Хоёр. Эд хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор акталж, акталснаас гарсан эргэлтийн хөрөнгийг тооцож хөрөнгө борлуулсаний орлогод төвлөрүүлэн данснаас хассаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэж, тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Г.Тувааны нэрэмжит Дундговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга (Х.Жаргал)-д даалгасугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.С. С.СҮХБААТАР



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 13 дугаар сарын  
13-ний өдрийн 10 тогтоолын хавсралт



**Нэгдсэн эмнэлгийн актлаж, данснаас хасах барилга байгууламжийн мэдээлэл**

№	Барилга. байгууламжийн нэр	Зориулалт	Хүчин чадал		Ашиглагдаж орсон огноо	Ашиглагдаж буй хугацаа /жилээр/	Тоо	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан эзлэгдэл	Үлдэгдэл өртөг
			Хэмжээ	Биет хэмжээ							
1	Гражийн контор	Эмнэлэг	Ш	1	1986	34	1	3,978,816	3,785,401.20	193,414.80	
2	Гражийн Путик	Эмнэлэг	Ш	1	1986	34	1	281,500	281,500	-	
3	Автогражийн склад	Агуулах	Ш	1	2019	13	1	13,389,800	425,073.04	12,964,726.96	
4	Автограж	Эмнэлэг	Ш	1	2019	13	1	22,502,700	1,153,984.64	21,348,715.36	
<p><b>Нийт дүн</b></p> <p><b>40,152,816 /дочин сая нэг зуун тавин хоёр мянга найман зуун арван зургаа төгрөг/</b></p> <p><b>5,645,958.88 /таван сая зургаан зуун дөчин таван мянга есөн зуун тавин найм төгрөг/</b></p> <p><b>наян найман мөнгө</b></p> <p><b>34,506,857.12/ Гучин дөрвөн сая таван зуун зургаан мянга найман зуун тавин долоо төгрөг/ арван хоёр мөнгө</b></p>											